



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 03 сарын 17 өдөр

Дугаар 5/52

Хэрлэн сум

Түр орлон гүйцэтгэгч томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 30.1.15, 30.1.16, 2014 оны "Төрийн зарим албан хаагчийн цалингийн талаар авах арга хэмжээний тухай" 75 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Хэрлэн сумын 8 дугаар цэцэрлэгийн эрхлэгч С.Оюунгэрэл нь өөр ажилд шилжсэн тул Д.Нэргүйг 2017 оны 03 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн тус цэцэрлэгийн эрхлэгчийн үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилсугай.

Хоёр. Цэцэрлэгийн эрхлэгчийн үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилогдож байгаа Д.Нэргүйн цалинг ТҮБД-н 6-ын 2 дугаар шатлал 628022 /зургаан зуун хорин найман мянга хорин хоёр/ төгрөгөөр тогтоож, цалинжуулахыг цэцэрлэгийн няглан бодогч /Н.Энхтуяа/-д зөвшөөрсүгэй.

Гурав. Эрхлэгчийн ажлыг мэргэжил арга зүй, удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Боловсрол, соёл, урлагийн газар /С.Мөнхцэцэг/-т үүрэг болгосугай.

Дөрөв. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс /Г.Лхагвахатан/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Н.ГАНБЯМБА

